

"Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 3 дугаар хавсралт

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ (2025 он)

№	Үйл ажиллагаа		Шалгуур үзүүлэлт	Зорилтот	Хүрсэн	Тайлбар
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх						
1	Засгийн газар, төрийн	1	Нийт сургалт, зөвлөгөөний тоо семинар	30	39	ЕБС, хүүхдийн цэцэрлэгийн багш, ажилтанд мэргэжлийн зэрэг олгох хасах журмын хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх нь сэдэвт сургалтад 36 сургалтын менежер, 16 цэцэрлэгийн аргазүйчийг хамруулан мэргэжлийн зэргийн цахим системийг ашиглах заавар, журмын онцлог заалтуудын хэрэгжилтэд анхаарах асуудлын талаар мэдээлэл хүргэлээ. Байгууллагын менежментийг сайжруулахад багш, ажилчдын үүрэг оролцоо сэдэвт сургалтад ЕБС-ийн 672 багш, удирдах ажилтныг хамруулан зохион байгуулж багшийн болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулах арга зүйн сургалт, явцын үнэлгээний арга зүй, Суралцагч төвтэй, идэвхтэй сургалтын аргазүй, Багш нарын мэргэжлийн бүлгээр ажиллах арга зүй зэрэг багшийн өдөр тутмын ажилд дэмжлэг үзүүлэх арга зүйн олон талт сургалтуудыг зохион байгуулж 2403 албан хаагчийг хамруулсан байна. Багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх төрөлжсөн сургалтыг 10 төрлийн агуулгаар зохион байгуулж давхардсан тоогоор 1900 багш, удирдах ажилтныг хамрууллаа. Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх, хичээлийн жилийн зорилго, зорилтын хэрэгжилтийг хангах, Гамшгийн эрсдлийн үеийн сургалтын бэлэн байдлыг хангах чиглэлээр 14 төрлийн сургалтад 1277 албан хаагч, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хүүхдийн хөгжил хамгаалал, хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааг хангах чиглэлээр 5 төрлийн сургалтад 505 албан хаагчийг хамрууллаа.
		Үүнээс	Ажлын байран дах сургалт	100	100	Багшийг ээлжит хичээлийн цахим контент бэлтгэх чадварт сургах зорилгоор 22 сургууль 22 цэцэрлэгийн 800 гаруй багшийг мозайк цахим систем ашиглах болон хиймэл оюун ухааныг ашиглах сургалтад хамруулан мэргэшүүлснээр бага ангийн иргэний ёс зүйн боловсрол, дүрслэх урлаг, математик, монгол хэл, англи хэлний хичээлийн агуулгаар багаараа хамтран цахим хичээл бэлтгэн үндэсний хэмжээний ээлжит хичээлийн цахим санд 182 хичээлийг байршуулсан байна. Боловсролын газрын зөвлөн туслах багийн

				үйлчилгээний хүрээнд 2025 онд сумдын 20 сургууль, 22 цэцэрлэгт хүрч ажиллан, хүний нөөцийн удирдлагын мэдээллийн систем, тушаал шийдвэрийн хэрэгжилт, хууль, эрх зүйн үндэслэлийг тодорхойлох, бичиг баримтын боловсруулалтын стандарт, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн, хичээл сургалтын үйл ажиллагаанд зөвлөн туслалаа. сургууль, цэцэрлэгийн багш, удирдлагууд, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, хоол зүйчдийн тусгайлсан сургалтуудыг цахимаар нийт 250, танхимаар 340 гаран удаа зохион байгуулсан. 2025 оны 9 дүгээр сараас 6-н сургуульд 15 судлагдахууны 142 багшийн 142 цагийн буюу 5680 минутын хичээлд сууж, арга зүйн зөвлөмж дэмжлэг үзүүллээ.
	Мэргэшүүлэх сургалт	10	12	Багшийн мэргэжил дээшлүүлэх төрөлжсөн сургалтын хүрээнд заавал судлах 6, сонгон судлах 4 нийт 10 чиглэлээр 1900 багш удирдах ажилтныг мэргэжил дээшлүүлэх 3 кредит цагийн багц сургалтад хамрууллаа. Мөн хөгжим, дүрслэх урлаг технологийн багш нарын буриад улсад зохион байгуулагдсан мэргэшүүлэх сургалтад 44 багшийг хамруулсан.
	Туршлага солилцох арга хэмжээ	5	7	Мэргэжлийн хөгжлийн бүлгийн туршлага солилцох арга хэмжээний хүрээнд 44 сургалтын 94 бүлгийн сайн туршлагыг солилцох үйл ажиллагаанд 845 багш удирдах ажилтныг хамруулж, үндэсний хэмжээнд 2 сургуулийн сайн туршлагыг түгээн дэлгэрүүллээ. Мөн сайн хичээл арга хэмжээний хүрээнд 300 багш хичээл зохион байгуулах ур чадвар, туршлагаа солилцлоо. Амжилтын гараа хөтөлбөрийн хүрээнд 216 бага боловсролын багш, Англи хэлтэй Булган хөтөлбөрийн хүрээнд 67 багш арга туршлагаа солилцов. Боловсролын салбарын ажилтан албан хаагчдыг сурган мэргэшүүлэх гадаад, дотоодод туршлага судлах сургалтын чиглэлээр БНСУ-ын Хусо Их сургуульд 20 багш, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат хотын Ажил мэргэжлийн дээд сургуульд Политехникийн коллежийн 3 багш, ОХУ-д боловсролын сургалтын байгууллагад 11 хөгжмийн багш, 3 захирал, 28 технологийн багш, Буриад улсын Хөдөө аж ахуйн коллежид 4 багш, Япон улсад 1 багш, Хөх хотод 3 ахлах арга зүйч, 1 багш зэрэг гадаад улсад нийт 74 багш, удирдах ажилтнууд туршлага судлан сургалтад хамрагдсан байна.
2	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо	3876	4100	Боловсролын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх чиглэлээр сургалтад давхардсан тоогоор нийт 4100 албан хаагч 100 хувь хамрагдсан байна.
Үүнээс	Эмэгтэй албан хаагч	1993	3556	
	Эрэгтэй албан хаагч	876	544	

			Удирдах албан тушаалтан	256	260	Албан хаагчдын 93.4 хувь нь БЯ, БЕГ, БХ, БҮТ, БОМСТ, аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан танхимын сургалтад хамрагдсан байна.
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	751	854	
		3	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	91.6	93.4	
2	Албан хаагчдыг	1	Нийт гадаад сургалт, семинар зөвлөгөөний тоо	5	9	Боловсролын салбарын ажилтан албан хаагчдыг сурган мэргэшүүлэх гадаад, дотоодод туршлага судлах сургалтын чиглэлээр БНСУ-ын Хусо Их сургуульд 20 багш, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат хотын Ажил мэргэжлийн дээд сургуульд Политехникийн коллежийн 3 багш, ОХУ-д боловсролын сургалтын байгууллагад 11 хөгжмийн багш, 3 захирал, 28 технологийн багш, Буриад улсын Хөдөө аж ахуйн коллежид 4 багш, Япон улсад 1 багш, Хөх хотод 3 ахлах арга зүйч, 1 багш зэрэг гадаад улсад нийт 74 багш, удирдах ажилтнууд туршлага судлан сургалтад хамрагдсан байна.
		2	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо	80	74	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	67	48	
			Эрэгтэй албан хаагч	13	26	
			Удирдах албан тушаалтан	68	16	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	10	58	
		3	Гадаад сургалтад хамруулсан байдал	4	9	
3	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	1	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	-	132.7 сая	Орон нутгийн болон үндсэн сургалт, гадаад дотоодод туршлага судлах сургалтуудад нийт 132.7 сая төгрөгийг улсын болон орон нутгийн төсвөөс зарцуулаад байна.
		2	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	1030	1035	Боловсролын салбарын удирдах ажилтны албан хаагчдын шилжилт хөдөлгөөн 2024-2025 оны хичээлийн жилийн статистикийн мэдээгээр 282 ажилтан буюу 27 хувь нь өөр аймаг, хотын эсвэл тухайн аймаг, хот дотроо, боловсролын бус байгууллага, хувиараа ажил эрхлэх, тэтгэвэрт гарсан, бусад зэрэг шалтгаанаар сургууль, цэцэрлэгт шилжсэн байна.
Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах						
1	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	1	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	76%	76%	Засгийн Газрын 2019 оны 5-р тогтоолын дагуу гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулалд 2025 онд ЕБС-д 882,5 сая, СӨБ-д 512,3 сая, байгууллагын үнэлгээгээр үнэлэгдсэн 1 сургуулийн нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 8,8 сая, 8 цэцэрлэгт 52,4 сая төгрөг төсөвлөгдөн зарцуулсан.
		2	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг)	5.000	5.000	БЕХууль, Байгууллагын дотоод журмуудад зааснаар цалингийн санд багтаан сургууль, цэцэрлэг сар бүр унаа хоолны мөнгийг 5000 мянгаар тооцож олгон сургууль, цэцэрлэгийн 1700 гаруй багш ажилтанд 1,4 тэрбум төгрөгийг олгож байна.

2	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцлийг бүрдүүлэх	1	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)	75	80	Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар аргачлалаар ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгыг хагас, бүтэн жилээр 2 удаа байгууллагын нийт албан хаагчдаас авч 96.65 хувьтай үнэлэгдсэн. Мөн Боловсролын салбарын нийт 1917 албан хаагч буюу салбарын 80 хувийг сэтгэл ханамжийн судалгаанд хамруулж гарсан санал, санаачлагыг үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.
3	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	1	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэх (Жилд)	1	1	Эрүүл мэндийн сайдын 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/139 дугаар тушаалаар баталсан “Урьдчилсан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношлогоо, шинжилгээ”-нд нийт албан хаагчид тогтмол хамрагдаж байна.
		2	Албан хаагчдын хамрагдалт	80	100	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгийн үзлэгт 1917 ажилтан албан хаагч хамрагдахаас 1125 багш, ажилтан хамрагдаж, үзлэг оношилгооны хамрагдалт 56.8 хувьд хүрсэн бөгөөд 30.1 сая төгрөгийг зарцуулсан байна.
4	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	1	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая. төг)	35.5 сая	97 сая	Боловсролын ерөнхий хуулийн 13.3.3-т заасан хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан багш ажилтанд 5, 3 жил тутамд олгох мөнгөн урамшуулалыг 2025 онд ЕБС-ийн 237 багш ажилтанд 2,8 тэрбум, СӨБ-ийн 58 багш ажилтанд 473,6 сая төгрөгийг төсөвлөн зарцуулсан. Мөн БЕХ-ийн 13.3.4-т заасан тэтгэвэрт гарах багш нарт нэг удаагийн тэтгэмж ЕБС-ийн 31 багш ажилтанд 840,6 сая, СӨБ-ын 27 багш ажилтанд 774,8 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөн зарлага санхүүжилт хийгдэж байна. 2025 онд орон нутгийн төсвөөс БНСУ-д туршлага судалсан 20 багшид 20.0 сая, элсэлтийн шалгалтад амжилт гаргасан 1 багшид 1.0 сая, боловсролын салбарын шилдэг 3 алба хаагчид тус бүр 1.0 сая төгрөг, нийт 25.0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлээ. Мөн 20 сургуулийн 45 албан хаагчид улс, орон нутгийн төсвөөс 18.4 сая төгрөгийн мөнгөн дэмжлэг үзүүлсэн байна. Багш нарын мэргэжлийг дээшлүүлэх үндэсний болон орон нутгийн төрөлжсөн сургалтад ерөнхий боловсролын 20 сургуулийн 632 багш, 36 сургалтын менежер, 17 захирал нийт 685 албан хаагчийг, сургуулийн өмнөх боловсролын 22 байгууллагын 147 багш, 20 эрхлэгч, 16 аргазүйч нийт 183 албан хаагчийг хамруулж байна. Үндэсний сургалтад 31.1 сая, орон нутгийн сургалтад 65.8 сая төгрөг нийт 97.0 сая төгрөгийг зарцуулаад байна.

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН БИЕЛЭЛТ

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь																								
Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал																											
1.1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн	Боловсролын газрын төсвийн шууд захирагч, Булган аймгийн Засаг даргын хооронд Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 2025 оны гэрээнд нийт 8 зорилт, 82 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гэрээнд тусгагдсан байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар <table><tr><th rowspan="2">Биелэлтийн хувь</th><th colspan="6">Биелэлт /хувь/</th><th>Дүн</th></tr><tr><th>100</th><th>90</th><th>70</th><th>50</th><th>30</th><th>0</th><th>Хугацаа хойшилсон</th></tr><tr><td>Арга хэмжээний тоо</td><td>44</td><td>27</td><td>2</td><td>8</td><td>1</td><td>-</td><td>-</td><td>90.2%</td></tr></table> 2025 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 90.2 хувьтай байна. Гэрээний хэрэгжилтийг хэрэгжүүлэхдээ Боловсролын газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтэс болон сургалт арга зүйн хэлтэс тус тус гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусгаж, нэгж судлагдахуун хариуцсан арга зүйч болон сургууль, цэцэрлэгийн удирдлагуудийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулан ажилласан.	Биелэлтийн хувь	Биелэлт /хувь/						Дүн	100	90	70	50	30	0	Хугацаа хойшилсон	Арга хэмжээний тоо	44	27	2	8	1	-	-	90.2%	90.2
Биелэлтийн хувь	Биелэлт /хувь/						Дүн																				
	100	90	70	50	30	0	Хугацаа хойшилсон																				
Арга хэмжээний тоо	44	27	2	8	1	-	-	90.2%																			
1.2	Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг	Боловсролын яамны сайдын 2024 онд Б/137 тоот тушаалаар Боловсролын газар нь байгууллагын дарга, 2 хэлтэстэй /Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, сургалт арга зүйн хэлтэс/ 29 албан хаагчтайгаар бүтцийг баталсан. БГ-ын үйл ажиллагааг http://www.facebook.com/bulgan.bsg, https://edu.bu.gov.mn/home вэб болон пэйж хуудсаар салбарын бүх байгууллага, орон нутгийн ба төрийн байгууллагуудад цахимаар мэдээлэл хүргэж байна. Хаяг, байршил: Булган, Булган, 5-р баг, Жаргалант, Гудамж-Дамбын 2-р гудамж, Байр-207, шуудангийн хайрцаг-88 Утас: 70343414, 70342274	100																								
1.3	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн	Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2025 онд “Үндсэн чиглэлийн биелэлт”-ийн боловсролын салбарт хамаарахаар тусгагдсан үзүүлэлтүүдийн биелэлт 99.1 хувьтай байна.	99.1																								

	хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж		
1.4	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан	Аймгийн Иргэдийн төлөөлөгчийн хурлын тогтоолын 29 арга хэмжээний хэрэгжилт 100 хувьтай байна. Үүнээс 3 арга хэмжээний хэрэгжилтийг тооцох боломжгүй. Мөн аймгийн хэмжээнд мөрдөгдөж буй хууль тогтоомж, Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын албан даалгавар нийт 34 арга хэмжээ 2025 оны байдлаар 93.11 хувьтай хэрэгжиж байна.	93.11
1.5	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан	Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт” хөтөлбөрт тусгагдсан Боловсролын бодлогын чиглэлээр 4 дэд “Амжилтын гараа”, “Код бичих”, “Англи хэлтэй Булган”, “Чадварлаг мэргэжилтэн” хөтөлбөрүүд батлагдаж, хөтөлбөр хэрэгжсэнээс хойш хийсэн ажлын явц 55 хувьтай байна.	55
1.6	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт	Аймгийн Иргэдийн төлөөлөгчийн хурлын тогтоолын 29 арга хэмжээний хэрэгжилт 100 хувьтай байна. Үүнээс 3 арга хэмжээний хэрэгжилтийг тооцох боломжгүй. Мөн аймгийн хэмжээнд мөрдөгдөж буй хууль тогтоомж, Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын албан даалгавар нийт 34 арга хэмжээ 2025 оны байдлаар 93.11 хувьтай хэрэгжиж байна. Төрийн албаны тухай хууль, ИТБАТГӨГШ – тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Авлигын эсрэг хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, Монгол улсын нэгдсэн төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Архивын тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай зэрэг хуулиуд болон бусад тогтоол, шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.	93.11
1.7	Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг	Боловсролын газрын даргын 2025 оны А/21 дугаар тушаалаар Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эрхлэгчийн, мөн даргын 2025 оны А/04 дугаар тушаалаар сургуулийн захирлын албан тушаалын тодорхойлолтыг батлан хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн Боловсролын газрын ТҮ ангиллын албан хаагчдын ажлын байр, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталгаажуулсан. Албаны харилцах утас: 70343414, 70342274 Албаны цахим шуудангийн хаяг: bulgan@mecs.gov.mn	100
1.8	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ	2025 онд БГ-т иргэдээс бичгээр нийт 26 өргөдөл ирсэн. Эдгээрийг ангилж үзвэл бичгээр бүх өргөдөл ирсэн ба хугацаа болоогүй 5, бусад өргөдлийг 100 хувь шийдвэрлэн ажилласан. Өнгөрсөн онтой харьцуулахад өргөдөл, гомдлын тоо 0.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Эдгээр өргөдөл, гомдлыг тухай бүрт нь холбогдох хүмүүсээр нь	100

		шийдвэрлүүлэн өргөдөл, гомдлын мэдээг хагас, бүтэн жилээр аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтэс, Архивын хэлтэст тус тус хүргүүлэн ажилладаг.	
1.9	Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл	Статистикийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 5, 6, 9 дэх заалт болон Зөрчлийн тухай хуулийн 15 дугаар бүлгийн 25 дугаар зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн Ерөнхий боловсролын 22 сургуулийн “Байгууллага, ажилтан, бүлэг, суралцагч”, “Сургалтын орчин”, “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ”, “Сурах бичиг, сурдаггүй хүүхэд”, “Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан”, сургуулийн өмнөх боловсролын 22 цэцэрлэгийн “СӨБ-ын 10 дугаар сарын мэдээ”, “Сургалтын орчин”, “Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан” зэрэг нийт 8 төрлийн статистик мэдээг хянаж нэгтгэн БЕГ-т цахимаар хүргүүлээ. Мөн Боловсролын салбарын статистик мэдээг 44 байгууллагаас хүлээн авахдаа дээрх “Статистикийн болон зөрчлийн тухай” хуулийн дагуу үнэн зөв, бүрэн хамралттай, батлагдсан хугацаанд ирүүлэхэд анхаарах зорилгоор 29 сургалтын менежер, 5 эрхлэгч, 17 арга зүйч нарт 12 удаагийн цахим, 1 удаагийн танхимын уулзалтыг зохион байгуулж зөвлөгөө зөвлөмж, мэдээллээр ханган ажилласан. Боловсролын салбарт /44 байгууллага: 22 сургууль, 22 цэцэрлэг/ 575 бүлэгт өдрөөр 14546, дүйцсэн хөтөлбөрт 157 суралцагч суралцаж, 807 багш, 1000 ажилтан, албан хаагч ажиллаж байгаа бөгөөд нийт 29 дотуур байранд 1909 хүүхэд амьдарч байна.	100
1.10	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр	Хамаарахгүй	
Хэсгийн дундаж хувь:			92.28
Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
2.1	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл	Боловсролын яамны сайдын 2024 оны Б/137 тоот тушаалаар Боловсролын газар нь 29 үндсэн орон тоотойгоор бүтэц, орон тоо батлагдсан, 2025 оны эхэнд 8 орон тоо дутуу байснаас 3 сул орон тоонд төрийн албаны сул орон тоог нөхөх тусгай шалгалтаар орж тэнцсэн 3 албан хаагчийг томилсон. 1 албан хаагчийг бусад төрийн байгууллагаас шилжүүлэн томилсон. Одоогийн байдлаар тус газарт 4 сул орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна. 2025 оны 4 дүгээр улирлын тусгай шалгалтын хүрээнд сонгон шалгаруулалтад санал хүргүүлж, 1 иргэн “Байгалийн ухааны боловсрол хариуцсан ахлах арга зүйч”-ийн албан тушаалд 1 иргэн тэнцсэн, бусад 3 албан тушаалд шалгалт өгсөн иргэн байхгүй болно.	100
2.2	Албан хаагч, ажилтны сонгон шагаруулах журам	Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 25 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ыг баримтлан аймгийн ТАСЗ-д сул орон тооны захиалгыг 4 удаа хүргүүлэн ажилласан. Байгууллагын цахим хаягт сул орон тооны мэдээллийг тогтмол мэдээллэн ажиллаж байна. 2025 онд Боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч нарын 12 сул орон тоо /Хишиг-Өндөр, Рашаант, Сайхан, Орхон, Хялганат, Булган сумын	100

		Спортын ерөнхий боловсролын сургуулиудын захирал, Гурванбулаг, Бүрэгхангай, Хутаг-Өндөр, Булган сумын 1-р цэцэрлэг, Хялганат тосгоны цэцэрлэгийн эрхлэгч/-ны захиалгыг 3 удаа ТА3-д өгч, тусгай шалгалтанд тэнцсэн Рашаант, Хялганат, Булган сумын Спортын ерөнхий боловсролын сургуулийн захирал, Хялганат, Булган сумын 1-р цэцэрлэгийн эрхлэгчийг ТА3-ийн тогтоолыг үндэслэн томилон ажиллуулж байна. Одоогийн байдлаар Сэлэнгэ, Сайхан, Хишиг-Өндөр сумын сургуулийн захирал, Хутаг-Өндөр, Гурванбулаг, Бүрэгхангай, Булган сумын 2-р цэцэрлэгийн эрхлэгчийн орон тоо сул байна.	
2.3	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм	Төрийн өмчийн ерөнхий боловсролын 22 сургууль, 22 цэцэрлэг ёс зүйн дэд хороог байгуулан ажилласан. Нийт 22 сургуулийн 957 багш, ажилтан, 2792 эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарт, 22 цэцэрлэгийн 281 багш, ажилтан, 1893 эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд "Ёс зүй" сэдэвт сургалтыг 3 удаа зохион байгуулсан. Боловсролын салбарт 44 салбар байгууллагын 42 дэд хорооны зөвлөлтэй, 185 гишүүнтэй 2025-2026 оны хичээлийн жилд ажиллаж байна. Давхардсан тоогоор 112 удаагийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулж 1238 багш, ажилтан албан хаагчдыг хамруулсан. Ерөнхий боловсролын сургуулийн ёс зүйн зөвлөлүүд 6-12 дугаар ангийн 6100 гаруй сурагчдад ёс зүйн хэм хэмжээ, хандлага төлөвшил, хувь хүний хөгжил зэрэг сургалтуудыг зохион байгуулж ажиллалаа. Салбарын ёс зүйн өргөдөл, гомдол өмнөх оноос 0.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	100
2.4	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам	Байгууллагын хүний нөөцийн бодлого, байгууллагын стратеги төлөвлөгөөг шинэчлэн батлуулахаар ажлын хэсэг гарган төлөвлөлтийн ажлыг зохион байгуулж байна. Тус газраас Удирдлагын академид 3 албан хаагчийг дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад хамруулсан.	90
2.5	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ	Боловсролын газрын батлагдсан орон тоонд 8 үндсэн орон тоо /Төрийн захиргааны албан тушаал/ дутуу байснаас 2025 онд 4 удаа ТА3-д хүсэлт хүргүүлэн сонгон шалгаруулалт зарласан. Үүнээс 4 орон тоонд нөхөн хангалт хийсэн бөгөөд одоогийн байдлаар 4 албан тушаалын орон тоо сул байгаа. Мөн 4 дүгээр улирлын сул орон тоог нөхөх тусгай шалгалтад захиалга өгсөн. Тус газарт гарсан сул орон тооны талаархи мэдээллийг байгууллагын цахим сайт, хөдөлмөр, нийгмийн халамжийн газарт бүртгүүлсэн. Мөн байгууллагын алба хаагчдын дэлгэрэнгүй мэдээлэл, танилцуулгыг байгууллагын пэйж хуудсаар нээлттэй танилцуулан ажиллаж байна.	100
2.6	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам	2023 оны Засгийн газрын 98 дугаар тогтоолыг үндэслэн албан хаагчдын гүйцэтгэлийн тайланг үнэлэх аргачлалын дагуу улирал тутам үнэлж, хуулийн дагуу урамшуулал олгож байна. Мөн албан хаагчдын "Гүйцэтгэлийн төлөвлөгөө" болон хөдөлмөрийн гэрээг дүгнэхдээ тухайн удирдах болон гүйцэтгэх албан хаагчийн иргэдэд үзүүлсэн үйлчилгээний чанар, хүртээмжийг харгалзан дүгнэх зорилгоор сэтгэл ханамжийн судалгааг хагас, бүтэн жилээр жилд 2 удаа багш, арга зүйч нараас авсан. Боловсролын газрын алба хаагчид болон аймгийн сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарын 2025 оны 1, 2, 3-р улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг алба хаагчдаас 100	100

		хувь авч дүгнэсэн. 2025 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний биелэлтийг хүлээн авч байна.	
Хэсгийн дундаж хувь:			98.3
Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх			
3.1	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл	Сургууль, цэцэрлэгийн 2025 оны төсөв 2024 оны 8 дугаар сарын 28-нд гаргасан Засгийн газрын 53 дугаар тогтоолын дагуу хувьсах зардлаар Боловсролын ерөнхий газраас хуваарилагдан санхүүгийн үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан. 2025 оны хувьд ерөнхий боловсролын сургууль 50.7, хүүхдийн цэцэрлэгт 19.9 нийт 70.6 тэрбум төгрөг хуваарилагдан ирээд зарлага санхүүжилт хийгдэж байна. 2026 оны төсвийн төслийг энэ оны 7 дугаар сард 45 байгууллагаар цахимаар хүлээн авч, хянаж нэгтгэн Боловсролын ерөнхий газрын холбогдох мэргэжилтэнгүүдэд цахимаар болон цаасаар хүргүүлэн ажилласан.	100
3.2	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан	2025 оны хагас жилийн байдлаар боловсролын салбарын санхүүжилт 41.5 тэрбум төгрөг, 2025 оны эхний үлдэгдэл 6.7 тэрбум төгрөг, өөрийн орлогоор 239.3 сая төгрөг, хагас жилийн гүйцэтгэлээр 37.9 тэрбум төгрөг байна. Харин үндсэн хөрөнгө 8.5 төгрөг, бараа материалын тайлан 166.6 сая төгрөг болсон.	100
3.3	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	Нийт боловсролын салбарт 22 сургууль, 22 цэцэрлэг, 1 насан туршийн боловсролын төв, 1 коллеж, нийт 46 байгууллага боловсролын үйл ажиллагаа явуулдаг. 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд салбарын хэмжээнд өөрчлөлтгүй санал дүгнэлт 46 байгууллага авсан. Боловсролын ерөнхий газрын 2025.08.25-ны өдрийн №1/3077 тоот албан бичгийн хүрээнд боловсролын газар болон зарим боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийсэн. Энэ ажлын хүрээнд Гурванбулаг, Хялганат, Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр, Булган сумын 1, 2, 7-р цэцэрлэг, Боловсролын газар, Насан туршийн боловсролын төв, Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр, Булган сумын 1, 2, 3, спортын сургуулиуд тус тус хамрагдсан байна.	100
3.4	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ	Хууль тогтоомжийн дагуу ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн түрээсийн сурах бичгийн хураамж 31.3 сая, мөн ерөнхий боловсролын сургуулиудын биеийн тамирын заалны орлого, бусад 23.8 сая, сумын болон аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс санхүүжүүлсэн 137.8 сая, нийт 192.9 сая төгрөгийг байгууллагуудын үндсэн дансанд төвлөрүүлэн Боловсролын ерөнхий газраас зарцуулах эрх авснаар гүйцэтгэлийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	100
3.5	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	Жилийн эцсийн тайлан гараагүй учраас хэтрэлт, хэмнэлтийн тооцоо тайлбар гараагүй болно.	100

3.6	Таван сая, түүнээс дээш төгрөгний үнийн дүн бүхий хуалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	Сургууль, цэцэрлэгийн хэмжээнд хуулийн хугацаанд мэдээллийг оруулан ажилладаг.	100
3.7	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгний үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт	Сургууль, цэцэрлэг мэдээлэлийг тус бүрдээ хуулийн хугацаанд оруулдаг. Боловсролын Газрын хувьд 2,254,1 сая төгрөгийг 269 багшид хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллахад олгодог 1 удаагийн тэтгэмж, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж зардлаас 874,4 сая төгрөгийг 33 хүнд олгосон байна.	100
3.8	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр	Хуулийн дагуу шилэн дансанд хугацаанд нь мэдээлэл байршуулдаг.	100
3.9	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл	Боловсролын салбарын шилэн дансны мэдээллийг сургууль, цэцэрлэгээр 2025 оны 3 дугаар улирлын байдлаар хянаж үзэхэд ерөнхий боловсролын сургууль 2896 мэдээлэл оруулахаас 2851 мэдээлэл байршуулан 45 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна. Харин сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хувьд 3 дугаар улирлын байдлаар 2772 мэдээлэл оруулахаас мэдээлэл байршуулах хугацаандаа 2744 мэдээллийг байршуулж 28 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн. Хугацаа хоцорсон мэдээллийн тоо эхний хагас жилд 20-оос 28 болж нэмэгдсэн бол мэдээлэл оруулаагүй тохиолдол 2-оос 0 болж буурсан. 2025 оны 12 дугаар сарын 4-ний байдлаар Бүрэгхангай, Баяннуур, Хишиг-Өндөр, Дашинчилэн, Рашаант сумдын Боловсролын байгууллагуудад хийсэн хяналт шалгалтаар 10 актаар 6,204.5 мянган төгрөгийн төлбөр тогтоож тайлант хугацаанд 7 актын 2,680.4 мянган төгрөгийг барагдуулж, 3 актын төлбөрийн үлдэгдэл 3,254.1 мянган төгрөгийн төлбөр байна.	100
3.10	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үедэслэл, шалтгаан	Тендерийн тухай хуульд зааснаар байгууллага тус бүр тухайн жилийн төсвийн хөтөлбөр зориулалтын дагуу тендер зарлаж ажилладаг. Мөн хуулийн хугацаанд шилэн дансанд байршууладаг.	100

3.11	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт	Бүх шатны Төсвийн шууд захирагч нар Төсвийн байгууллагын байнгын хэрэгцээт бараа, ажил үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах тухай хуульд нийцүүлэн зохион байгуулж, орон нутгийн үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэгчдээс худалдан авалт хийн ажиллаж байна. Орон нутгийн жижиг, дунд хүнс үйлдвэрлэгчдийг дэмжиж ажлын хүрээнд орон нутгийн жижиг дунд бизнес эрхлэгч, сумын малчин айл өрхөөс жилд дунджаар 45115.3 тн мах махан бүтээгдэхүүн, сүү сүүн бүтээгдэхүүн 5926 литр, төмс, хүнсний ногоо 26709.96 кг нийт 1,5 сая төгрөгийн худалдан авалт хийсэн. Хангал, Хишиг-Өндөр, Дашинчилэн, Гурванбулаг, Тэшиг, Булган сумын 2-р сурууль нь туслах аж ахуйтай нийт 38,9 сая төгрөгийн малтай байна.	100
3.12	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл	Хамаарахгүй	
3.13	Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн	Хамаарахгүй	
3.14	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан	Хамаарахгүй	
Хэсгийн дундаж хувь:			100
Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн байдал			
4.1	Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл	Хамаарахгүй	
4.2	Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа	Сургалтын байгууллагын ажил эрхлэх зөвшөөрлийг хуулийн дагуу олгож байна. Сургуулийн өмнөх боловсрол 2027 он хүртэл, суурь боловсролын сургуулиуд 2026, 2028 он хүртэл хүчинтэй. Ерөнхний боловсролын 9 сургуулийн тусгай зөвшөөрөл сунгах хүсэлтийг зөвшөөрлийн цахим системд мэдээллийг бүртгэж хүсэлтийг хүргүүлэн ажилласан.	80
Хэсгийн дундаж хувь:			80

Хэрэгжилтийн дундаж хувь:

92.6
хувь

ТАНИЛЦСАН:

БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН ДАРГА

Ц.ЦОЛМОНБААТАР

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Г.НАНСАЛМАА

ХШҮ-НИЙ АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.СОЛОНГОМАА